



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨВ ЗҮТГЭЭ!

№106 /106/ 2021.08.05

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ҮЙЛ ЯВДАЛ

ӨГСӨН ҮҮРГИЙНХЭЭ БИЕЛЭЛТИЙГ ШАЛГАЛАА



ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар Цэргийн албаны хэлтсийн бүрэлдэхүүнд өгсөн үүргийнхээ биелэлтийг өчигдөр шалгаж, албаны хэрэг хөтлөлт болон баримт бичгийн боловсруулалт, мэдээллийн сангийн ажлын явцтай танилцлаа.

Энэ үеэр ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтсийн дарга, цэргийн цагдаагийн дарга, хурандаа Н.Лхагвасүрэн шинээр зохион байгуулагдсан хэлтсээс өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чиглэлээр танилцуулга

хийсэн бөгөөд Зэвсэгт хүчинд сүүлийн 10 жилд гарсан гэмт хэрэг, сахилгын зөрчлийн мэдээллийн санг бүрдүүлэн, ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрлийн Улаанбаатар хотод ирж суралцах урьдчилсан төлөвтэй тул хичээл эхлэх хугацааг ялгаатай тогтоосон байна.

судалгааг гарган дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон талаар илтгэсэн юм.

Мөн Цэргийн албаны хэлтэс нь ажил, үүргийнхээ хуваарийн дагуу ЗХЖШ-ын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилуулсан бөгөөд энэхүү зөвлөлийн үйл ажиллагааг жил, улирал, сараар төлөвлөн хэрэгжилтийг нь хангаж байгаагийн зэрэгцээ энэ онд ээлжит болон ээлжит бус дөрвөн удаагийн хуралдааныг зохион байгуулжээ. Тэрчлэн Зэвсэгт хүчний цэргийн хүрээ, хотхонд үүрэг гүйцэтгэх цэргийн цагдаагийн нэгжүүдэд албан тушаалтнуудыг томилуулж, үүрэг гүйцэтгэх боломжийг нь тодорхойлсны зэрэгцээ "Цэргийн цагдаагийн ажиллагааны журам"-ын дагуу үүрэг гүйцэтгүүлж хэвшсэн талаарх мэдээллийг хүргэв.

ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар өгсөн үүргийнхээ хэрэгжилттэй танилцах явцдаа цэргийн цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцас, зарим тусгай тоног хэрэгслүүдийг ашиглах талаарх зарим хувилбаруудтай танилцаж, санал солилцсон ба цаашид олон улсын жишигт тохируулан улам бүр боловсронгуй болгох чиглэлээр үүрэг өглөө.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААН

ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙГ 9 ДҮГЭЭР САРД ЭХЛҮҮЛНЭ



Монгол Улсын Засгийн газар өчигдөр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хичээлийн шинэ жилийг есдүгээр сард эхлүүлнэ. Бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс үе шаттайгаар эхлүүлэх,

бэлтгэл хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албаны хүмүүст Засгийн газрын хуралдаанаас даалгав.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний

өдрөөс, их, дээд сургууль, коллежийн хичээлийг 9 дүгээр сарын 1-нээс цахимаар, 13-наас танхимаар эхлүүлнэ. Их, дээд сургуульд хөдөө, орон нутгаас 74.5 мянган оюутан Улаанбаатар хотод ирж суралцах урьдчилсан төлөвтэй тул хичээл эхлэх хугацааг ялгаатай тогтоосон байна.

Хичээлийг халдварын тархалтын нөхцөл байдалтай уялдуулан танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр зохион байгуулна. Халдвар илрээгүй ногоон түвшинд байгаа ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтыг танхимаар зохион байгуулна. Хүн хоорондын зай баримтлан анги танхимын багтаамжаас хамаарч нэг анги, бүлэгт хичээллэх хүүхдийн тоо 20-25 байна.

Аймгийн төв, нийслэлд байршилтай ерөнхий боловсролын сургууль болон халдвар илэрсэн тохиолдолд бүс нутаг дахь ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид хоёр бүлэгт хуваагдаж

танхимд тав хоног, гэр бүлийн орчинд тав хоногт зайн, цахим хэлбэрээр тус тус ээлжлэн хичээллэнэ.

Цэцэрлэгт эхний ээлжид дөрөв, таван настай хүүхдүүдийг танхимаар хамруулна. 2-3 настай хүүхдийг коронавируст халдварын нөхцөл байдал болон улирлын томуу, томуу төст өвчлөлийн вакцинжуулалттай уялдуулан цэцэрлэгт үе шаттай хамруулна.

Энэ хичээлийн жилд 1.515 цэцэрлэгт 232,000 хүүхэд, 854 сургуульд 718,817 сурагч, 75 МСҮТ-д 40,165 суралцагч, 88 дээд сургуульд 150,100 оюутан суралцана.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, политехникийн коллежийн багш, ажилчдын 90 гаруй хувь нь коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан. Мөн 8 дугаар сарын 2-ны байдлаар 12-17 насны нийт хүүхдийн 74.8 хувь нь дархлаажуулалтад хамрагдаад байна гэж БШУ-ны сайд Л.Энх-Амгалан хэллээ.

Үргэлжлэл нь арын нүүрт!

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
168.673 +1444	150.328 +2288	833 +6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ	ЭДГЭРСЭН
4180 +75	209 +28	3893 +31

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 200,932,027
Эдгэрсэн
Нийт: 180,891,231
Нас барсан
Нийт: 4,268,936

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	☁️ 7
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	☁️ 20
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	☁️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.848.0	2.851.0
EUR 🇪🇺	3.38.0	3.395.0
CNY 🇨🇳	441.5	442.5
RUB 🇷🇺	38.40	39.60
JPY 🇯🇵	25.85	26.40
KRW 🇰🇷	2.43	2.53

ЗУРХАЙ

2021.08.05 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 26/

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН ДОЛООН УЛААН ХӨХӨГЧИН ХӨХӨГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:
Өлзийтэй сайн
 Наран ургах, шингэх:
05:34-20:22

Барилдлага:
 Үл зохилдох
 Шүтэн барилдлага:
 Хурьцахуй

Суудал:
Шороо
 Өдрийн наран 5 цаг 34 минутад мандан, 20 цаг 22 минутад жаргана. Тухайн өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал худалдан авах, мал түгээх, сахил санааар авах, хануур, төөнүүр хийлгэх, хийморийн дарцаг хатгахад сайн. Эрдэнийг гадагш өгөх, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Хүүхдийн сэвлэг үргээлгэх буюу үс засуулахад тохиромжгүй бөгөөд нүд бүрэлзэн улцайна хэмээжээ.

ДЕЛЬТА ХУВИЛБАР АНХЛАРАХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

Суулгах, Хамар битүүрх, нус гоожих, Булчин өвдөх, Урт хугацаагаар толгой өвдөх, Бөөлжих, Хоолой өвдөх, Бие тавиурх, идрах.

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ.

ЦАГ ҮЕ

ӨНӨӨДӨР АЖИЛЛАХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦЭГҮҮД



Энэ сарын 4-нд нийслэлийн хэмжээнд I тунд 2077, II тунд 916, нийт 2993 иргэнийг дархлаажууллаа. В а к ц и н ж у л а л т эхэлснээс хойш нийслэлийн 18-аас дээш насны 1.086.416 иргэн I тунд, 989.820 иргэн II тунд хамрагдаад байна. Мөн нийт 2075 жирэмсэн эх, 12-15 насны 31.829 /31.4%/, 16-17 насны 16.578 /48.9%]

хүүхэд тус тус II тунд хамрагдлаа. Өнөөдөр ажиллах шинжилгээний цэгийн байршлыг хүргэж байна. • Баянгол дүүрэгт 96 дугаар цэцэрлэг • Сүхбаатар дүүрэгт 143 дугаар цэцэрлэг • Чингэлтэй дүүрэгт 50 дугаар сургууль • Баянзүрх дүүрэгт Авто оношилгооны төвийн

зогсоолд явуулын цэг • Сонгинохайрхан дүүрэгт 5 шарын төмөр замын гармын урд байрлах Номин агуулах байрны гадаа явуулын цэг • Хан-Уул дүүрэгт Буянт-Ухаа спорт цогцолборын гадаа талбайд явуулын цэг ажиллаж байна. Тү р г э в ч и л с э н шинжилгээг 09:00-12:00 цагийн хооронд авах юм.

ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙГ 9 ДҮГЭЭР САРД ЭХЛҮҮЛНЭ

Түрүүч нь эхний нүүрт!

Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилт 33 хувьтай байна

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Сангийн яам танилцуулаа.

Тус төлөвлөгөөний нийт гүйцэтгэл 33.3 хувь, 2021 оны гүйцэтгэл 54.2 хувь байна.

Ажлын байрыг дэмжих хоёр их наядын зээлийн гүйцэтгэл 88 хувь буюу 1.7 их наяд төгрөгийн зээл олгожээ. Рело санхүүжилтийн зээл 623,5 тэрбум, ипотекийн зээл 561,6 тэрбум, хөдөө аж ахуйн зээл 319,6 тэрбум төгрөг гаргаад байна. Нийт хөтөлбөрийн хүрээнд 216 мянган ажлын байр хадгалж үлдлээ гэж Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Хэвлэн нийтлэх, эрэн сурвалжлах, мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг хангасан эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарна

Авлигын индексийг бууруулах зорилго бүхий Ажлын хэсгийн ажлын явцын талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав. Ажлын хэсэг нь 2021-2022 онд авлигын төсөөллийн индексийн Монгол Улсын үнэлгээг өсгөх хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж байна.

Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, хууль бус үйлдлийг мэдээлсэн, илчилсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон гэмт хэргийн хохилогч болохоос хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс Шүгэл үлээгчдийг хамгаалах тухай, сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх, эрэн сурвалжлах, мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг хангасан эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төслийг боловсруулахыг Ажлын хэсгийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгалаа.

Хүнд суртал, авлигын шинжтэй гомдол, саналаа иргэд 1111 төвд ирүүлж байгаа ажээ. Өнгөрөгч 7 дугаар сарын 22-30-нд ирсэн дуудлагын 114 нь хүнд сурталтай холбоотой байжээ.

Харьяа дүүргийн Газрын албаны үйл ажиллагааны хүнд суртал, төрийн байгууллагууд иргэдээс ирсэн дуудлагыг хүлээн авахгүй байх, төрийн зарим үйлчилгээ иргэдэд ойлгомжгүй, тодруулах

байгууллага, албан тушаалтан нь тодорхойгүй байгааг иргэд шүүмжилж байна.

Шил, шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк байгуулна

Шил, шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Эрдэслазм” ХХК-д таван жилийн хугацаатай олголоо. Паркийн дэд бүтцийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд технологи ашиглан барьж байгуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болголоо.

Монгол Улс шил, шилэн бүтээгдэхүүнийг 100 хувь импортоор худалдан авдаг, үүнээс 80 орчим хувь нь БНХАУ-аас хамаарч байна. 2020 оны мэдээгээр 21 нэр төрлийн 55 сая ам.долларын бүтээгдэхүүн импортоор худалдан авч дотоодын үйлдвэрүүд шилний хэрэгцээгээ хангадаг байна.

-Парк бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэхэд жилд 50 гаруй сая ам.долларын шил, шилэн хийцийн импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

-Эхний ээлжид ашиглалтад орох савлагааны шилний үйлдвэр нь хоногт 68,8 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ

-Улаанбаатар хотоос гарч байгаа шилний хог хаягдлын 30 хувийг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

Нийслэлийн Багахангай дүүрэгт байгуулагдах шил, шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк нь нийт гурван үйлдвэрийн бүстэй бөгөөд эхний ээлжид байгуулагдах савлагааны шилний үйлдвэр нь жилд дунджаар 48 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, улс, орон нутгийн төсөвт жилд дунджаар 10 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлж, 380 гаруй ажлын байр шинээр бий болгох урьдчилсан тооцоо хийгджээ.

“Тавантолгой-Зүүнбаян” төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэхийг үүрэг болгов

“Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулаа.

Үүнтэй холбогдуулан, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэсэн ажлын хүлээгдэж байгаа төлбөр болон төслийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах үлдэгдэл санхүүжилтийг 2021 оны гуравдугаар улиралд

багтаан шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт даалгав. Санхүүжилтийг шийдвэрлэсний үндсэн дээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажлыг 2022 оны хоёрдугаар улиралд багтаан ашиглалтад оруулахыг холбогдох хүмүүст үүрэг болгов.

Богдхан төмөр замын суурь бүтцийн барилгын ажил гуравдугаар улиралд эхэлнэ

Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгож, суурь бүтцийн барилгын ажлыг 2021 оны гуравдугаар улиралд багтаан эхлүүлэхээр болов.

Богдхан төмөр замын төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх, төслийн бүтээн байгуулалт, төмөр замын суурь бүтцийн барилгын ажилд Зэвсэгт хүчний Жанжин штаб, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийг оролцуулахыг холбогдох хүмүүст үүрэг даалгалаа.

Товч мэдээ

• Замын-Үүд боомтын ачаа бараа эргэлтийг сайжруулах, БНХАУ-ын Тяньжин боомтод бөөгнөрсөн чингэлгийг татан авах чиглэлээр гадаад харилцааны шугамаар холбогдох арга хэмжээ авах, 8 дугаар сард багтаан БНХАУ-ын талд үүссэн олон улсын ачаа тээвэртэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэхийг албаны хүмүүст даалгалаа.

• Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэн үргэлжлүүлэх, хувийн хэвшлийн оруулсан хөрөнгө оруулалтыг аудитын дүгнэлт гаргуулан Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК-ийн балансд шилжүүлэх, Үйлдвэрлэлийн үндсэн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж ажиллахыг даалгав.

• Хилийн Алтанбулаг боомтоор зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон хугацааг 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгалаа.

• Автозамаар олон улсын зорчигч тээвэрлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэн дэмжээд тус хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамж гаргахаар тогтов.

Эх сурвалж: ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ГАЗАР


НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС #UB ХАМТДАА

2021.08.05-НД АЖИЛЛАХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Д/Д	ДҮҮРЭГ	ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ГАЗАР	БАЙРШИЛ	НЭГ ӨДӨРТ АВАХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТОО
1	Баянгол	96-р цэцэрлэг	3,4-р хорооллын эцэс, Говь сауны урд талд	150
2	Сүхбаатар	143-р цэцэрлэг	Скайтел ХХК-ийн баруун урд талд	120
3	Чингэлтэй	50-р сургууль	Баянбүрд төвийн урд талд	100
4	Баянзүрх	Шинжилгээ авах явуулын баг	Баянзүрх дүүргийн Авто оношлогооны төвийн зогсоол	100
5	Сонгинохайрхан	Шинжилгээ авах явуулын баг	5 шарын төмөр замын гарамын урд байрлах Номин агуулах байрны гадаа	150
6	Хан-Уул	Шинжилгээ авах явуулын баг	Буянт-Ухаа спорт цогцолборын гадаа талбай	100

09:00-12:00 ЦАГИЙН ХООРОНД ТҮРГЭВЧИЛСЭН ШИНЖИЛГЭЭ АВНА

АЛТАЙ, ХАНГАЙ, ХӨВСГӨЛИЙН УУЛАРХАГ НУТГААР ДУУ ЦАХИЛГААНТАЙ ААДАР БОРОО ОРНО



өдөртөө 24-26 градус дулаан байна.

Багануур орчмоор: Багавтар үүлтэй. Бороо орохгүй. Салхи баруун хойноос секундэд 7-12 метр. Шөнөдөө 6-8 градус, өдөртөө 23-25 градус дулаан байна.

Тэрэлж орчмоор: Багавтар үүлтэй. Бороо орохгүй. Салхи баруун хойноос секундэд 5-10 метр. Шөнөдөө 4-6 градус, өдөртөө 22-24 градус дулаан байна.

Энэ сарын 10-ныг хүртэлх цаг агаарын урьдчилсан төлөв: • 6-нд баруун аймгуудын нутгийн хойд, төвийн аймгуудын нутгийн баруун хэсгээр, • 7-нд баруун аймгуудын нутгийн зарим газар, төвийн аймгуудын ихэнх нутгаар, • 8-нд нутгийн хойд хэсгээр, • 9-нд баруун аймгуудын нутгийн зүүн, говийн аймгуудын нутгийн хойд хэсэг, төв болон зүүн аймгуудын нутгийн зарим газраар бороо, дуу цахилгаантай аадар бороо орно.

Салхи нутгийн зарим газраар борооны өмнө түр зуур ширүүснэ. Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг, Хүрэнбэлчир орчим, Завхан голын эх, Тэрэлж голын хөндийгөөр 3-8 градус, Их нууруудын хотгор болон говийн бүс нутгийн баруун өмнөд хэсгээр 14-19 градус, бусад нутгаар 8-13 градус, өдөртөө Монгол-Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар 17-22 градус, Их нууруудын хотгор, говийн бүс нутгийн өмнөд хэсгээр 28-33 градус, бусад нутгаар 22-27 градус дулаан байна.

Улаанбаатар хот орчмоор: Багавтар үүлтэй. Бороо орохгүй. Салхи баруун хойноос секундэд 6-11 метр. Шөнөдөө 9-11 градус, метр, баруун болон төвийн аймгуудын нутгийн зарим газраар борооны өмнө түр зуур ширүүснэ. Агаарын температур: Шөнөдөө Монгол-Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтэйн уулархаг нутаг, Хүрэнбэлчир орчим, Завхан голын эх, Тэрэлж голын хөндийгөөр шөнөдөө 4-9 градус, өдөртөө 17-22 градус, Орхон, Сэлэнгийн сав газар болон говийн бүс нутгаар шөнөдөө 16-21 градус, өдөртөө 28-33 градус, бусад нутгаар шөнөдөө 11-16 градус, өдөртөө 22-27 градус дулаан байна. 7-ноос нутгийн хойд хэсгээр бага зэрэг сэрүүснэ.

Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар дуу цахилгаантай аадар бороо орох тул мөндөр, нөөлөг салхи, аянга цахилгаан, үер усны аюулаас сэрэмжтэй байхыг ЦУОШГ-аас анхааруулав.

Өнөөдөр 20 цаг хүртэлх цаг агаарын урьдчилсан мэдээ:

Хур тунадас: Баруун болон зүүн аймгуудын нутгаар үлшинэ, бусад нутгаар солигдмол үүлтэй. Шөнөдөө зүүн аймгуудын нутгийн зарим газраар, өдөртөө баруун аймгуудын нутгийн хойд, төвийн аймгуудын нутгийн баруун, зүүн аймгуудын нутгийн зүүн хэсгээр бороо, дуу цахилгаантай аадар бороо орно.

Салхи: Нутгийн зүүн хагаст баруун хойноос, бусад нутгаар баруун өмнөөс секундэд 6-11

